

**“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2026 оны 06 дугаар сарын 29

Улаанбаатар хот

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Газрын “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдөр газрын даргын А/22 дугаар тушаалаар батлуулав.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/66 дугаар тушаалаар батлагдсан “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам”-ын дагуу 2026 оны 1 дүгээр улирлын тайлан мэдээг Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн албажуулж 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/1425 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд Ерр.Ulaanbaatar.mn өргөдөл, гомдлын программд нийт 115 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Үүнд: иргэнээс 111, албан хаагчаас 4 өргөдөл, гомдол бүртгэгдсэн ба хугацаандаа шийдвэрлэгдсэн 92 буюу 80 хувь, судлагдаж байгаа 23 буюу 20 хувь өргөдөл, гомдол байна.

Тайлант хугацаанд өдөрт нь багтаан хүлээн аваагүй 8, явцын тэмдэглэл хөтлөөгүй 1 зөрчил бүртгэгдсэн.

2026 оны өргөдөл, гомдлыг 2025 онтой харьцуулбал:



Өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 43,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

➤ Албан хаагчаас 4 хүсэлт ирүүлснээс:

Шийдвэрлэгдсэн: Цалингүй чөлөө хүссэн-1, Жирэмсний амралт авах тухай-2, Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай-1, хүсэлт ирүүлснийг Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Түвшинжаргал тухай бүрт нь газрын даргын тушаалаар албажуулан шийдвэрлэв.

➤ Иргэнээс 111 өргөдөл, гомдол ирүүлсэнээс:

Явган хүний зам, талбайн тохижилтын тухай, Барилга, байгууламж барих, өргөтгөх тухай, Сургуулийн барилга, байгууламж, газар, хөрөнгө оруулалтын тухай, Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилт, ашиглалт, хамгаалалтын тухай, Боловсролын байгууллагын барилга, байгууламж, газрын тухай, Дулааны шугам сүлжээний гэмтэл, засвар, үйлчилгээний тухай, Нийтийн эд аж ахуйн ашиглалт,

үйлчилгээний тухай, Авто зам, гүүрийн засвар, үйлчилгээ, ажлын гүйцэтгэл, явцын тухай, Баригдаж буй барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангуулах тухай, Орон сууцны дээврийн засвар, үйлчилгээний тухай, Ерөнхий боловсролын үйлчилгээний тухай, Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны доголдолтой байдлын тухай, Авто зам, гүүрийн эвдрэл, гэмтлийн тухай, Баригдаж буй барилга, байгууламж чанарын шаардлага хангаж байгаа эсэх тухай, Барилга, байгууламжийн маргаантай асуудлыг шийдвэрлэх тухай, Хальтиргаа, гулгаа цэвэрлэгээний тухай, Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай худалдаа, үйлчилгээний тухай, Дулааны шугам сүлжээний засвар, үйлчилгээний тухай, Иргэн хоорондын газрын маргааныг шийдвэрлүүлэх тухай, Боловсролын салбарын үйл ажиллагааны тухай, Ногоон байгууламжийн тохижилт, хамгаалалтын тухай, Явган зорчигч, явган хүний гарцын тухай, Барилга, байгууламж буулгах тухай, Санхүүжилтийн тухай, Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тухай, Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламж, газрын тухай, Нийслэлийн Өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны тухай, Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай, Төвлөрсөн цахилгаан хангамжид хамрагдах тухай, Архивын лавлагаа, мэдээлэл хүсэх тухай, Орон сууцны айлуудын засварын ажлын тухай, Ашиглалтад орсон барилга, байгууламж чанарын шаардлага хангахгүй байгаа тухай, Авто зам, гүүрийн ажлын төлөвлөлтийн тухай ирүүлснийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 92 өргөдөл, гомдлыг шийдвэрлэгдэж, 23 өргөдөл, гомдол судлагдаж байна.

ТАНИЛЦСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

 Ц.ГУРБАДАМ

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

 А.СОЛОНГО

ТАЙЛАН БИЧСЭН:
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 Т.ИЧИНХОРЛОО